

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 12.00 цагт Төрийн нарийн бичгийн даргын хуралдааны танхимд боллоо.

Ёслолын ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Энхбат, Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Жамбалцэрэн, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүү, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Т.Гантогтох, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Совд, Худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний зохицуулалтын хэлтсийн дарга О.Онон болон яамны газар, хэлтсийн албан хаагчид оролцлоо.



Төрийн захиргааны албан хаагчаар томилогдсон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Сайнхүү, мэргэжилтэн Ц.Мөнхнасан, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ц.Цэцэгбадам, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Д.Оюун-Эрдэнэ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн Г.Мөнхмаргад нар **“Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ”** хэмээн Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөлөө.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ